

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2023/39/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баян-Өлгий аймаг 2023 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Х.Еркебулан Утас: 92921881 Цахим хаяг:erkebulankh@ audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

2023 о.н. 24 № 248  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог үйл явдал гараагүй байна.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>10,061,812.00</u></b>	<b><u>14,153,500.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	9,311,812.00	14,153,500.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,311,812.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	14,153,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	750,000.00	-
35600	Мал амьтад	750,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>719,882,829.76</u></b>	<b><u>917,622,749.76</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	719,882,829.76	917,622,749.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	679,784,829.76	877,674,749.76
	Барилга, байгууламж, орон сууц	669,441,499.93	955,181,499.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(153,514,498.64)	(201,698,904.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	52,762,492.00	52,762,492.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,723,293.38)	(36,625,081.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,547,566.00	46,247,566.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,667,269.61)	(27,416,755.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,950,698.00	42,838,298.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,519,364.62)	(38,131,364.58)
39209	Зам, гүүрийн байгууламж	65,000,000.00	65,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(34,999,999.92)	(47,999,999.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	161,048,000.00	161,048,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(71,818,000.00)	(93,808,000.00)
39217	Ном	277,000.00	277,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	40,098,000.00	39,948,000.00
39301	Програм хангамж	1,936,400.00	1,936,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,461,400.00)	(1,611,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,623,000.00	39,623,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>729,944,641.76</u></b>	<b><u>931,776,249.76</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>24,870,252.00</u></b>	<b><u>12,932,321.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	24,870,252.00	12,932,321.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	24,870,252.00	12,932,321.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	24,870,252.00	12,253,956.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	678,365.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>705,074,389.76</u></b>	<b><u>918,843,928.76</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	705,074,389.76	918,843,928.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	326,816,008.00	326,816,008.00
51101	Өмч: - төрийн	326,816,008.00	326,816,008.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	203,928,604.91	417,698,143.91
51210	Өмнөх үеийн үр дүн	225,934,564.23	203,928,604.91
51220	Тайлант үеийн үр дүн	(22,005,959.32)	213,769,539.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	174,329,776.85	174,329,776.85

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>729,944,641.76</u></b>	<b><u>931,776,249.76</u></b>
---	--	------------------------------	------------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>429,821,964.00</b>	<b>702,879,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>63,400,000.00</b>	<b>317,804,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	63,400,000.00	291,740,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	63,400,000.00	291,740,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	63,400,000.00	291,740,000.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	26,064,200.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	-	26,064,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>366,421,964.00</b>	<b>385,075,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,492,264.00	2,239,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,492,264.00	1,939,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	364,929,700.00	382,836,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	364,929,700.00	382,836,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>451,827,923.32</b>	<b>489,110,161.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>451,574,419.32</b>	<b>488,360,161.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	442,074,419.32	462,294,981.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	222,924,265.00	234,483,939.00
210101	Үндсэн цалин	200,625,248.00	193,337,434.00
210102	Нэмэгдэл		(1,874,023.00)
210105	Гэрээт ажлын хөлс	22,299,017.00	43,020,528.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	67,339,915.00	61,850,630.00
210201	Тэтгэврийн даатгал	41,945,877.00	36,222,232.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,155,167.00	10,092,668.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,146,886.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	5,097,089.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	9,994,896.00	15,535,730.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,464,552.00	21,027,768.00
210301	Гэрэл, цахилгаан	493,340.00	708,168.00
210302	Түлш, халаалт	11,971,212.00	20,319,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,248,810.40	12,945,665.00
210401	Бичиг хэрэг	2,183,700.00	865,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,928,710.40	10,614,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,048,400.00	1,400,325.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	65,700.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	457,000.00	152,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	152,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	219,100.00	917,000.00
210604	Урсгал засвар	219,100.00	917,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,169,400.00	2,118,000.00
210702	Дотоод албан томилолт	2,169,400.00	2,118,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,787,800.00	10,044,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,660,400.00	8,849,520.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	378,700.00	470,400.00
210807	Газрын төлбөр	37,300.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	65,000.00	48,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	109,463,576.92	118,755,959.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,980,976.00	20,792,579.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	375,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,982,600.92	97,587,680.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,500,000.00	26,065,180.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	26,064,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	26,064,200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,500,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,500,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	980.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	980.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>253,504.00</b>	<b>750,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	253,504.00	750,000.00
223001	Бусад хөрөнгө	-	750,000.00
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	253,504.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(22,005,959.32)</b>	<b>213,769,539.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(22,005,959.32)</b>	<b>213,769,539.00</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>366,421,964.00</u></b>	<b><u>396,986,200.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>26,064,200.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	26,064,200.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		26,064,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>366,421,964.00</b>	<b>370,922,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,492,264.00	2,239,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,492,264.00	1,939,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	364,929,700.00	368,682,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	364,929,700.00	368,682,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>366,421,964.00</u></b>	<b><u>393,398,600.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>366,421,964.00</b>	<b>393,398,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>356,921,964.00</b>	<b>367,333,420.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	248,519,700.00	266,492,053.00
210101	Үндсэн цалин	176,414,000.00	177,918,802.00
210102	Нэмэгдэл	48,067,000.00	61,466,998.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,038,700.00	27,106,253.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,550,200.00	33,019,900.00
210201	Тэтгэврийн даатгал	23,609,500.00	21,944,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,485,200.00	3,368,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,988,100.00	2,055,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	497,000.00	513,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,970,400.00	5,137,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,180,300.00	21,027,768.00
210301	Гэрэл, цахилгаан	1,104,800.00	708,168.00
210302	Түлш, халаалт	12,075,500.00	20,319,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,939,100.00	10,908,300.00
210401	Бичиг хэрэг	2,183,700.00	924,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,619,000.00	8,315,775.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,048,400.00	1,602,825.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	65,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	457,000.00	152,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	152,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,135,700.00	917,000.00
210604	Урсгал засвар	1,135,700.00	917,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,169,400.00	2,039,500.00
210702	Дотоод албан томилолт	2,169,400.00	2,039,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,277,800.00	7,901,020.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,150,400.00	6,867,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	378,700.00	296,800.00
210807	Газрын төлбөр	37,300.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	65,000.00	61,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,692,764.00</b>	<b>24,875,879.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,192,764.00	24,417,179.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	458,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,500,000.00</b>	<b>26,065,180.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	26,064,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		26,064,200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,500,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,500,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	980.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	980.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	≡	<b><u>3,587,600.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>3,587,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,587,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	3,587,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,587,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	≡	<b><u>(3,587,600.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин олгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь нэмэлтийн нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	225,934,564.23		727,080,349.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	225,934,564.23	0.00	727,080,349.08

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд лээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-22,005,959.32		-22,005,959.32
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	203,928,604.91	0.00	705,074,389.76
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	203,928,604.91	0.00	705,074,389.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	203,928,604.91	0.00	705,074,389.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд лээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			213,769,539.00		213,769,539.00
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	417,698,143.91	0.00	918,843,928.76

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	408,900,500.00	394,746,020.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	408,900,500.00	394,746,020.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	382,836,300.00	368,681,820.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	279,046,600.00	266,492,053.00
210101	Үндсэн цалин	179,023,500.00	177,918,802.00
210102	Нэмэгдэл	61,518,300.00	61,466,998.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,504,800.00	27,106,253.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,019,900.00	33,019,900.00
210201	Тэтгэврийн даатгал	21,944,400.00	21,944,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,368,900.00	3,368,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,055,100.00	2,055,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	513,800.00	513,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,137,700.00	5,137,700.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,184,600.00	21,027,768.00

210301	Гэрэл, цахилгаан	865,000.00	708,168.00
210302	Түлш, халаалт	20,319,600.00	20,319,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,195,500.00	9,469,100.00
210401	Бичиг хэрэг	1,101,800.00	924,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,937,000.00	6,906,575.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,068,700.00	1,572,825.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	65,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	457,000.00	152,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	152,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,100,000.00	917,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	917,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,739,500.00	1,739,500.00
210702	Дотоод албан томилолт	1,739,500.00	1,739,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,716,600.00	11,488,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,529,200.00	10,454,720.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,900.00	178,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	378,700.00	296,800.00
210807	Газрын төлбөр	37,300.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	65,000.00	61,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,376,600.00	24,375,879.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,917,900.00	23,917,179.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	458,700.00	458,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	26,064,200.00	26,064,200.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	26,064,200.00	26,064,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	26,064,200.00	26,064,200.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	408,900,500.00	394,746,020.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	372,161,900.00	394,746,020.00
132001	Орон нутгийн төсвөөс	346,097,700.00	368,681,820.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	26,064,200.00	26,064,200.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	36,738,600.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	36,738,600.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00

<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1492264.00</b>	<b>2,239,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1492264.00</b>	<b>2,239,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1492264.00	2,239,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	1,439,200.00
210402	Тээвэр, шатахуун		1,409,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		30,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	300,000.00
210702	Дотоод албан томилолт		300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1492264.00	500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1492264.00	500,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1492264.00	2,239,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1492264.00	2,239,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1492264.00	1,939,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		300,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь “Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан, төрийн бодлого шийдвэр, аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлог, давуу талд түшиглэсэн хөгжлийн хэтийн чиг хандлагыг оновчтой тодорхойлж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хөнгөн шуурхай, ил тод явуулж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад оршино” гэсэн чиг үүрэгтэйгээ нийцсэн зорилго, зорилт дэвшүүлж хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- ❖ Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ❖ Шилэн дансны тухай хууль
- ❖ Татварын тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж ажилладаггүй. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

*Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар*

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 201.8 сая төгрөгөөр буюу 27.7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	9,311.8	14,153.5	4,841.7
Бараа материал	750.0	0	-750.0
Үндсэн хөрөнгө	719,882.8	917,622.7	197,739.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>729,944.5</b>	<b>931,776.2</b>	<b>201,831.7</b>
Өр төлбөр	24,870.2	12,932.3	-11,937.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	705,074.4	918,843.9	213,769.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>729,944.6</b>	<b>931,776.2</b>	<b>201,831.6</b>

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өөрчлөлт гарсан байна.

Оны эхний авлагыг барагдуулж, оны эцэст орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 14.1 сая төгрөгийн санхүүжилтийн авлагатай гарсан байна.

Оны эхэнд бараа материалын данс 0.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 29.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 29.9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст үлдэгдэлгүй гарчээ.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 719.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 3.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 291.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгөд 97.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Оны эцэст 12.9 сая төгрөгийн өр төлбөртэй гарсны 12.2 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн, 0.7 сая төгрөг нь бусад өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 213.8 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 213.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлттэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засаг даргын тамгын газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 374.8 сая, нийт зарлагыг 374.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 34.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 408.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 408.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 394.7 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 394.7 сая төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 14.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	306,344.8	293,190.3	13,154.5	95.7
2	80102-Туслах үйл ажиллагааны зардал	63,491.5	62,491.5	1,000.0	98.4
3	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	10,000.0	10,000.0	-	100.0
4	82801-Улсын баяр наадам	3,000.0	3,000.0	-	100.0
5	823401-ОНХСан итгэлцүүрээр олгох	26,064.2	26,064.2	-	100.0
	<b>Дүн</b>	<b>408,900.5</b>	<b>394,746.0</b>	<b>14,154.5</b>	<b>96.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Статистикийн хэлтсээс 2.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч, үүнээс тээвэр шатахууны зардалд 1.4 сая төгрөг, дотоод томилолтын зардал 0.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Буянт сумын Засаг даргын тамгын газарт 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 366.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бараа үйлчилгээний бусад зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардлаас 0.001 сая төгрөгийг хэмнэж зарцуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад хуулийн дагуу мэдээллээ хугацаанд нь бүрэн оруулсан байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 100% байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 40.5 сая төгрөгийн 2 заалттай зөвлөмж, 1.5 сая төгрөгийн 1 заалттай албан шаардлага өгсөн. Зөрчлийг арилгаж зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2022.11.21 №214 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1.5	1	1.5	100
Зөвлөмж	2	40.5	2	40.5	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>42.0</b>	<b>3</b>	<b>42.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

#### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Нийт зөрчил		Үүнээс									
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										